

- Нийгмийн амьдралд ороход шаардагдах бусад зөвлөгөө, тусламжийг үзүүлэх.

Түүнчлэн ихэнхи улс орнуудын пробацийн алба нь хуульч гэхээс илүү сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, социологч зэрэг мэргэжлийн хүмүүсийг албандаа ажиллуулдаг ба сайн дурын ажилтан, төрийн бус байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг өргөнөөр татан оролцуулдаг байна. Пробацийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр улс орнууд хорих ял эдлүүлэхэд гарах зардлаа хэмнээд зогсохгүй ял шийтгэгдэгсэдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх талд олон сөрөг асуудлыг шийдэж чадсан байна.

Энэ бүгдээс үзвэл:

- Монгол Улсад пробацийн үйл ажиллагааг жишиг хэлбэрээр бий болгон хөгжүүлэх,
- Хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх,
- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр амьдралын зөв хэв маягт оруулах,
- Хорих байгууллагаас суллагдасдыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх,
- Нийгмийн харилцаанд оролцох чадварт сургах, хөгжүүлэх,
- Шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх,
- Энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулах,
- Дээрх асуудлуудыг зохицуулсан эрх зүйн болон тогтолцооны шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна.

Б.СҮХ-ОЧИР

Монголын Мэргэжлийн
Нийгмийн Ажилтны
Нийгэмлэгийн захирал,
Улаанбаатар Их
Сургуулийн нийгмийн
ажлын багш, нийгмийн
ажлын магистр



ХОРИХ БАЙГУУЛЛАГАД САЙН ДУРЫН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

Нийгмийн шинжлэх ухаанд, ялангуяа нийгмийн халамжийн үйлчилгээнд сайн дурын нийгмийн үйлчилгээг гол тулгуур ойлголтоо болгон авч үздэг. Учир нь нийгмийн хөгжлийн үзэл баримтлалд хувь хүний хөгжил суурь бааз нь болж өгдөг. Улс төр, эдийн засаг нийгмийн хөгжилд нөлөөтэй боловч хүний хөгжлийг чухалчилдаг. Энэ нь улс эх орны хөгжилд улс төр тогтвортой, эдийн засаг өсөлттэй байх нь хэрэгтэй бөгөөд хүмүүс нь хөгжилтэй байх үед л эерэг нөлөөлөл үзүүлнэ гэсэн үг.

Нийгмийн тусламж дэмжлэг буюу нийгмийн халамж нь буяны, хүмүүнлэгийн, нийгмийн ажлын үйл ажиллагаагаар дамжин иргэдэд хүрдэг. Буяны үйл ажиллагаа нь эрт үеэс үүсэлтэй бөгөөд нас барсан үед л туслалцаа үзүүлэх гэсэн явцуу ойлголт биш юм. Харин өргөн хүрээнд авч үзвэл тусламж дэмжлэг шаардлагатай хүмүүст үзүүлэх нэг чиглэлийн нийгмийн туслалцаа юм. Жишээ нь: Төр болон иргэдээс тухайн тусламж авч буй хүнд чиглэсэн нэг үйл ажиллагаа юм.

Хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь хүнийг шууд тусламж дэмжлэг хүлээн авагч биш өөрөө өөрийнхөө нөхцөл байдлыг өөрчлөх чадвартай гэж үзээд

тухайн хүнд шууд дэмжлэг туслалцаа үзүүлэхээс татгалзаж, өөрийгөө өөрчлөх боломж нөхцлөөр хангаж өгөх үйл явцыг хэлнэ. Манайхан ярьдагчилан загасыг бус загас барих аргыг зааж өгнө гэсэн үг.

Нийгмийн ажлын үйл ажиллагаа нь дэмжлэг туслалцаа хэрэгцээтэй байгаа хүмүүст өөрийн асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж, хүмүүсийн оролцоо, өөрийн өөрийн нөөц боломжийг ашиглах нөхцөл байдлаар хангах үйл явц юм. Нийгмийн ажилтан үйлчллүлэгчийн асуудлыг шийдвэрлэгч бус хүмүүсийг өөрийн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжин туслагч юм.

Ардын хувьсгалаас өмнө сайн дурын нийгмийн үйлчилгээ байсан байдаг. Тухайлбал бүх нийтээрээ ядууст туслах, баяд, ноёд өөрсдийн харьяаны иргэдийг халамжлах, хамгаалах үйл ажиллагааг өрнүүлэх зэргийг дурьдаж болно.

Социализмын үед малаа нийгэмчлэх, хороо, нэгдэлд элсэх, илгээлтээр явах, татвар төлөх зэргийг дурьдаж болно. Энэ үед нийгмийн сайн дурын хөдөлгөөн ихээхэн ач холбодлоо өгсөн бөгөөд үүнийг өөрийн онцлогт тохируулан сайн ашиглаж байсан байдаг.

Ардчиллын үеэс нийгмийн байдал өөрчлөгдөж, үндсэн хуулиа шинээр батлан хүмүүсийн амьдрал дахин шинээр эхлэх болсон. Энэ нь хүмүүсийн сэтгэлгээнд нөлөөлж хуучин байсан болгон өөрчлөгдөх шаардлагатай болсон. Иймээс сайн дурын нийгмийн үйлчилгээ алдагдаж, хөгжлийн доод шатанд унаж, хүн болгон халамжинд хамрагдах хэмжээнд хүрсэн.

Н.В.Трикер сайн дурын ажилтан гэдэг нь бүс нутгийн нийгмийн халамжийн хөгжлийн төлөө хичээн зүтгэж, нийгмийн байгууллагад үнэ хөлсгүй сайн дураар ажилладаг хүн гэж тодорхойлжээ.

Сайн дурын үйл ажиллагааг уламжлалт ухагдахуун болох харилцан туслалцахтай уялдаатай авч үзэх хандлага ч байдаг. Нийгэм хөгжих тусам харилцан туслалцах холбоо нь илүү нягт бөгөөд зохицсон зохион байгуулалтаар хөгжиж ирсэн. Ийм харилцан туслалцаа нь өнөө үеийн сайн дурын үйл ажиллагааны эхлэлд томоохон үүрэг гүйцэтгэсэн.

Нийгэмд хүмүүс хоорондын харилцаа илүү хөгжих тутам түүгээр дамжуулж хэн нэгэнтэй холбоо тогтоох боломжийг олгож байдаг. Мөн амьдралын эрх чөлөөнөөс шалтгаалж ийм харилцан туслалцааны нэгдмэл холбоо нь илүүтэйгээр нэг нэгэндээ туслахаар хязгаарлагдахгүй, нийгмийн сайн сайхны төлөө эвлэлдэн нэгдэж, сайн дурын хөдөлгөөн зохион байгуулахдаа зэргээр өөрчлөгдөж байдаг.

Маргэрет Говаарт шууд өв залгамжлах, гэр бүл хамаатан садан, хөрш, найз нөхдийнхөө төлөөх үйлчилгээг сайн дурын үйл ажиллагаанаас хассан байдаг. Сайн дурын үйл ажиллагааг судалж буй дэлхийн дахины эрдэмтэд ерөнхийдөө тус үйлчилгээ нь зохион байгуулалт бүхий хүрээнд явагддаг гэж үздэг.

Монгол улсын хорих байгууллагын түүхэнд 1997 он хүртэлх хугацаанд Улс төр, хүмүүжлийн хэлтэс нэртэйгээр хорих ангиудад "Сурган хүмүүжүүлэгч" нар ажиллаж байсан бол 1997-2003 оноос хоригдолтой

холбогдсон бүхий л эрх зүйн харилцааг зохицуулж, тэдний эрх ашгийг хамгаалах, амьдрах, ажиллах орчинг чөлөөт амьдралд аль болохоор ойртуулан, иргэншүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зорилго чиглэлтэй “Ахуй дэглэмийн байцаагч” ажиллаж байсан байна.

2003 оноос “Нийгмийн ажилтан” гэсэн нэр томъёогоор хоригдогсдыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад нь туслах чиг үүрэг бүхий албан хаагчид ажиллаж байна. Манай орны хувьд хорихоос суллагдсан хүмүүсийг нийгмийн ажлын үйлчилгээнд зуучлах, туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин байхгүй байна. Харин Цагдаагийн байгууллагын тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад хорих байгууллагад байгаа болон суллагдсан хүмүүст тавих хяналтын талаар дэлгэрэнгүй зааж, тусгаж өгсөн байдаг.

Ялтныг нийгэмшүүлэхтэй холбоотой ХЗДХ-ийн сайдын 2009 оны 198 дугаар тушаал, ШШГЕГ-ын даргын 2009 оны 10 дугаар сарын 14-ны №А/91 тоот тушаалын хавсралтуудаар хөтөлбөр батлагдсан. Уг хөтөлбөр нь :

- Ял эдлэгсдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэн төлөвшүүлэх,
 - Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэн, хөдөлмөрийн дадал олгох,
 - Тэднийг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдтэй ойртуулах, эвлэрүүлэн зуучлах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, ялтныг суллан гарахад бэлтгэх зорилготой.
- Хорих байгууллагад нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг дараах хэлбэрээр хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хоригдогсдыг бүхий л талаас нь судлан, холбоо тогтоох

2. Хорих ял эдлэх, хоригдох явцад тулгарч буй ахуйн орчны болон бусад бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, яриа таниулга хийх

3. Хоригдогсдын хувийн нөөц боломжийг илрүүлэх, тэдгээрийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалтуудыг зохион байгуулах

4. Хоригдогсдын сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх, нөлөөллийн үйл ажиллагааг дотоод болон бусад албад, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх.

5. Хоригдогсдын хуулиар хориглоогүй эрхийг хангах, түүнийг гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

6. Хоригдогсдыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх

* * *

